

МОНГОЛ ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
(2025 оны жилийн эцэс)

2025 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт
Нэг. Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах чиг үүргийн хүрээнд: (ХЭЗБтХ-ийн 45.1.1.)				
1.1.	Хуульчийн мэргэжлийн шалгалтын програм хангамжийг сайжруулах	I-VI сард	Сорилын болон бодлогын шалгалтад ашиглаж буй программ хангамжид хөгжүүлэлт хийсэн байна	- Энэ жилийн программын шинэчлэлтийн ажлыг ирэх жил болгон хойшлуулсан. Шалтгаан нь Хуульчдын холбоо шинэ байр худалдан авч буйтай холбоотойгоор программыг шинэчлэх төсөв байхгүй.
1.2.	Хуульчийн мэргэжлийн шалгалтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах	I-X сард	Хуульчийн мэргэжлийн шалгалтыг холбогдох хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу алдаа, зөрчил, дутагдалгүй зохион байгуулсан байна	- Шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд Сорилгын ном болон бодлогын номыг хянах, боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2025 оны сорилгын ном 3 хэсгээс бүрдсэн нийт 4741 сорилгоос бүрдсэн 1072 хуудас бүхий номыг бэлтгэн гаргасан.
1.2.1.	Сорилгын шалгалтын бэлтгэл хангах	IV-V сард	1. Сорилгын асуултын тодорхой хувийг шинэчилж, хянуулсан байна. 2. Өмнөх сорилгыг дахин хянуулж, шаардлагатай тохиолдлуудыг өөрчилсөн байна. 3. 2025 оны сорилгын шалгалтын ном хэвлүүлж, худалдаанд гаргасан байна.	- Нэгдүгээр хэсэг (бүх хариултын D хувилбар зөв)-т 459 сорилго, хоёрдугаар хэсгийн (зөв хариулт өгөгдөөгүй, оролцогч өөрөө зөв хариултыг хууль шинжлэн судлах замаар олох) сорилго-120, гуравдугаар хэсгийн сорилго-18 нийт 597 сорилго шинээр зохиосон. Нийт 1000 ширхэгийг хэвлэж худалдаанд гаргасан.
1.2.2	Бодлогын шалгалтын бэлтгэл ажлыг хангах	IV-V сард	1. Бодлогын шалгалтын асуултыг шинээр	- Бодлогын шалгалтад орох бодлогыг шалгалтын хорооны даргын нууцлалтайгаар зохиолгосон бөгөөд

			зохиолгож, хянуулсан байна. 2. "Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргачлал – 2025" ном хэвлэгдэж нийтийн хүртээл болсон байна	бодлогын шалгалтын өдөр тухайн салбар эрх зүйн бодлогыг сугалж, шалгалтын программд оруулж энэ жилийн бодлогын шалгалт явагдсан. - "Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргачлал 2023" номыг 2 дахь удаагаа 500 хувь хэвлүүлж худалдаанд гаргасан.
1.3.	Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогчдод зориулсан сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлж, сургалт зохион байгуулах	IX сард	1. Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогчдод зориулсан Эрүүгийн эрх зүй, Захиргааны эрх зүй, Иргэний эрх зүйн салбар тус бүрээр сургалт зохион байгуулсан байна. 2. "Шалгалтын программ хангамжийг ашиглах арга зүй" сургалт зохион байгуулсан байна.	- Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогчдод зориулсан бодлого бодох аргачлалын сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрийн хүртэл 3 салбар эрх зүйн чиглэлээр 15 удаагийн сургалтыг зохион байгуулж, давтагдсан тоогоор 750 хүн хамрагдсан. Хамрагдсан суралцагч нараас үнэлгээ авсан бөгөөд судалгаанд оролцогчдын 90 хувь нь хамгийн өндөр буюу 4-5 оноогоор үнэлсэн. - "Шалгалтын программ хангамжийг ашиглах арга зүйн талаар ППТ бэлтгэж шалгалтад оролцогчдын цахим хаягт хүргүүлж, мэдээлэл өгсөн.
1.4.	Дүгнэх комиссын гишүүдэд салбар эрх зүйн бодлого дүгнэх аргачлалын сургалт зохион байгуулах	V, IX сард (2 удаа)	Эрүүгийн эрх зүй, Захиргааны эрх зүй, Иргэний эрх зүйн чиглэлээр дүгнэх комисст ажиллах гишүүдийг бэлтгэсэн байна.	- Хэрэгжээгүй.
1.5.	"Хуульчийн мэргэжлийн шалгалтын журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах	I-III сард	Эрх зүйн зохицуулалт боловсронгуй болсон байна.	- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараа журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал шийдэгдэнэ.
Зорилт 2. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох чиг үүргийн хүрээнд: (ХЭЗБТХ-ийн 45.1.2.) 66%				
2.1.	Хуульчдын нэгдсэн бүртгэлийг хөтлөх	Тухай бүр	Хуульчдын бүртгэлийг журмыг хэрэгжилтийг хангасан байх	- 2025 онд 99 эрх зүйчийг Хуульчдын холбооны гишүүнээр элсүүлж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон. Үүнээс 81 нь 2025

				оны хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн эрх зүйчид байв. - Шинээр бүртгэгдсэн хуульчдын бүртгэлийг бүртгэлийн нэгдсэн систем болох программд бүртгэж, мөн цаасан бүртгэлд бүртгэж байна. - 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 6609 хуульч бүртгэгдсэн байна. Үүнээс шүүгч 542, Прокурор 620, Өмгөөлөгч 2064, Нотариат 262, Бусад 3121 бүртгэлтэй байна.
2.2.	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, гишүүдэд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	I-III сард	ХЭЗБТХ-ийн төсөлд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэлийг тодорхой тусгасан санал боловсруулж Ажлын хэсэгт хүргүүлсэн байна.	- Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, гишүүдэд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг хуульчаас ирсэн өргөдөл хүсэлтийг хүлээн авч, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн дүгнэлт гаргасны дагуу Тамгын дарга болон Ерөнхийлөгчид танилцуулж, хууль дүрэм журмын дагуу тушаал шийдвэрийг гаргаж, хуульчид гарсан хариу шийдвэрийг мэдээлэх, холбогдох ажиллагааг цаг тухай бүрт нь хийж байна. - 2025 онд нийт Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, гишүүдэд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх зохицуулалтын хүрээнд: нийт 494 өргөдөл, хүсэлт хүлээн авсанаас албан бичиг-80, өргөдөл хүсэлт-414 хүлээн авч шийдвэрлүүлж, иргэд хуульчдын хүсэлтийг хангасан.
2.3.	Мэргэшсэн хуульч нэршил олгох орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Зөвлөлийн хуралд танилцуулах, цаашид тус орон	I-III сард	Мэргэшсэн хуульч нэршил хэрэглэх эрхийн батламж, түүнийг олгох журмын хэрэгжилтийг хангасан байна.	- Хэрэгжээгүй

	тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх			
Зорилт 3.Хуульчийн мэргэжлийн дүрэм сахиулах чиг үүргийн хүрээнд: (ХЭЗБтХ-ийн 45.1.5.) 8%				
3.1.	Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудлаар хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах	2 сард	1. Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудлаар хуулийн байгууллагуудын удирдах ажилтнуудын зөвлөгөөн зохион байгуулсан байна. 2. “Хуульчийн ёс зүй” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	- Хэрэгжээгүй
3.2.	Хуульчийн мэргэжлийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал	1 сард	Хуульчийн мэргэжлийн дүрэм, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж Хуульчдын холбооны Зөвлөл болон Хуульчдын Их Хуралд хэлэлцүүлсэн байна.	- Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн тушаалаар “Хуульчдын Холбооны дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсгийг Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн Т.Мөнх-Эрдэнэ ахалж, гишүүдээр Зөвлөлийн гишүүн Д.Оросоо, Ч.Отгонбаатар, Б.Өнөрмаа, Б.Батцэнгэл, Б.Баасандорж, Нарийн бичгийн даргаар Мэргэжилтэн Г.Болор-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийн эхний уулзалтыг 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 18 цагт цахим хэлбэрээр зохион байгуулсан. Уулзалтад ажлын хэсгийн ахлагч Т.Мөнх-Эрдэнэ, гишүүн Д.Оросоо, Ч.Отгонбаатар, Б. Өнөрмаа, Б.Батцэнгэл, нарийн бичгийн дарга Г.Болор-Эрдэнэ нар оролцлоо. Ажлын хэсгийн гишүүн Б.Баасандорж гадаадад томилолтой явж байгаа тул оролцох боломжгүй талаар мэдэгдсэн. Уулзалтаар Хуульчийн эрх

				зүйн байдлын тухай хууль болон Хуульчдын холбооны дүрмийг уншиж, судлахаар тохирч дараагийн уулзалтаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах саналуудаа бэлдэж ирэхийг ажлын хэсгийн ахлагч Т.Мөнх-Эрдэнэ үүрэг болгосон. Ажлын хэсгийн хоёрдугаар уулзалтыг 2025 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр 18 цагт Хуульчдын холбооны байранд зохион байгуулсан. Уулзалтад ажлын хэсгийн ахлагч Т.Мөнх-Эрдэнэ, Ч.Отгонбаатар, Б.Батцэнгэл, өмгөөлөгч Ч.Өнөржаргал, Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар оролцлоо. Ажлын хэсгийн гишүүн Б.Өнөрмаа, Б.Баасандорж, Д.Оросоо нар цахим хэлбэрээр оролцлоо. Уулзалтаар гишүүд дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухайлсан саналуудаа хэлэлцэж саналын томьёоллуудаа бэлдсэн. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцүүлэхтэй холбогдуулан Тамгын газраас 2025.10.28 - 2025.11.15 хүртэл, “Хуульчдын Холбооны дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсгээс саналын томьёоллыг боловсруулан 2025.12.01-2025.12.04-ний өдөр хүртэл дүрмийн төсөлд нийт хуульчдаас санал авахаар Хуульчдын холбооны info@mglbar.mn сайт болон Монголын Хуульчдын холбоо гэсэн фэйсбүүкийн пэйж хуудсаар дамжуулан мэдээлсэн. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.1
--	--	--	--	--

				дэх заалтад Хуульчдын Их хурал “Хуульчдын холбооны дүрэм батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж заасны дагуу Монголын Хуульчдын холбооны дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 6 дугаар Их хурлаар хэлэлцүүлэхээр ажлын хэсгийн гишүүн Ч.Отгонбаатар танилцуулж, нэмэлт өөрчлөлтийн төсөл батлагдсан. 100%
3.3.	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг олон нийтэд таниулах, сурталчлах, нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх	Жилдээ	1. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг олон нийтэд таниулах, сурталчлах цуврал постерыг улирал тутамд нийт 4 удаа гаргасан байна. 2. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, орон нутгийн хуульч нартай уулзалт хийсэн байна. 3. Хуульчийн ёс зүй” сэдвийн хүрээнд хэвлэл мэдээллийн хэлэлцүүлэг, нэвтрүүлэгт оролцсон байна.	- Хэрэгжээгүй
3.4.	Хуульчийн ёс зүйн сургалтын хөтөлбөрийн бодлого, арга зүйг тодорхойлж, ёс зүйн хичээлийн хөтөлбөр болон цахим сургалтын хөтөлбөрийг шинээр болон шинэчлэн боловсруулах, сургалт зохион байгуулах	I сард II сард III сард V сард	1. Хуульчийн ёс зүйн сургалтын хөтөлбөрийн бодлого, арга зүйг тодорхойлж, ёс зүйн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна. 2. Хуульчийн ёс зүйн сургалт зохион байгуулсан байна.	- Хэрэгжээгүй

			3. Хуульчийн ёс зүйн сургалтын чиглэлээр гадаад орны багш нарыг урьж сургалт оруулах, туршлага судлах 4. Хуульчийн ёс зүйн цахим сургалтын хөтөлбөр бэлтгэж Хуульчдын холбооны сургалтын сайтад байршуулсан байна.	
3.5.	Хуульчийн ёс зүйн хичээлийн сургагч багш бэлтгэх	IV сард	Хуульчийн ёс зүйн сургалтын хөтөлбөрийн хүрээнд ёс зүйн хичээлийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулж 10-аас цөөнгүй багш бэлтгэсэн байна.	- Хэрэгжээгүй
3.6.	Хуульчийн ёс зүйн асуудлаар сургалтын үр дүнг тодорхойлох, хуульчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийх	Хагас жил тутамд	Хуульчийн ёс зүйн асуудлаар судалгаа хийж, танилцуулга илтгэлийг 2 удаа гаргасан байна.	- Хэрэгжээгүй
3.7.	Хуульчийн ёс зүйн баримт бичгийн эмхэтгэл бэлтгэж, хэвлүүлэх	II-III сард	Шүүгч, Прокурор, Өмгөөлөгч, Нотариатч, бусад хуульчийн сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээг тодорхойлсон баримт бичгийн эмхэтгэл болон “Хуульчийн ёс зүйн асуудал, шинэчлэл” симпозиумын илтгэлийн эмхэтгэлийг цаасан болон цахим хэлбэрээр гаргасан байна.	- Хэрэгжээгүй
Зорилт 4. Хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд: (ХЭЗБтХ-ийн 45.1.3.) 54,5%				
4.1	Хуульчдаас өгсөн сургалтын хөтөлбөрийн сэдвийн санал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн 2025 оны Сургалтын	I улирал	2025 оны Хуульчийн үргэлжилсэн сургалтын ерөнхий чиглэл батлагдсан байна.	- Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар 2025 оны Хуульчийн үргэлжилсэн сургалтын

	ерөнхий чиглэл, хөтөлбөр батлах			ерөнхий чиглэлийг хэлэлцэн батласан. 100%
4.2.	Хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрүүдэд мониторинг хийж, санал, дүгнэлт боловсруулах	Тухай бүр	1. Сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна. 2. Журмын шаардлага хангаагүй, 2 жилийн хугацаа хэтэрсэн хөтөлбөрүүдийг шаардлага хангуулж, дахин магадлан итгэмжлэх эсэх асуудлыг шийдвэрлэсэн байна.	- 2025 онд Сургалтын хорооны хурлаар нийт 8 хөтөлбөрийг хэлэлцэж, магадлан итгэмжилжсэн. 100% - Журмын шаардлага хангаагүй, 2 жилийн хугацаа хэтэрсэн сургалтын хөтөлбөрийн жагсаалт гаргах ажлыг хийж байна. Мөн сургалтын хөтөлбөрт мониторинг хийж, сургагч багш нарыг шинэчлэн, хороодтой тодорхой байдлаар хамтран ажиллаж сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.100% - Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооноос сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлэх, эрэлт хэрэгцээг тодорхойлох, судалгааны үр дүнг үндэслэн сургалтын сэдвийг шинэчлэх хүрээнд нийт хуульчдын дунд 2025 оны 01 сарын 27-31-ний өдрийн хугацаанд санал асуулга явуулсан.
4.3.	Шинэ хуульчдад зориулсан сургалт зохион байгуулах	I улирал	Сургалт зохион байгуулагдсан байна	- Шинэ хуульчдад зориулсан 2 багц цагийн сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр цахимаар, 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр танхимаар тус тус зохион байгуулсан ба Тамгын газрын дарга Ш.Жолбарс “Монголын Хуульчдын холбооны бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн болон бусад хороодын үйл ажиллагаа, тэдгээрт оролцох боломж” сэдвээр, Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дарга Б.Өнөрмаа “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мөрдөгдөх дүрэм, журам, Хуульчийн ёс зүй, Хуульчийн үргэлжилсэн сургалтын агуулга, ач холбогдол”, Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн

				ойлголт, “Технологи үйлдэгдэж ашиглагдаж буй жендерт суурилсан хүчирхийлэл, сэдвээр тус тус хичээл заасан. Сургалтад 150 гаруй хуульч оролцсон. 100%
4.4.	“Менторшип” хөтөлбөр хэрэгжүүлэх	Жилдээ	Залуу чадавхжуулах хуульчдыг “Менторшип” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	- Менторшип хөтөлбөрийг Цагдаагийн Ерөнхий газрын Стратеги, бодлого төлөвлөлт, инновацийн газартай хамтран хэрэгжүүлэхээр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. 100%
4.5.	2025 оны Сургалтын үндсэн чиглэлийн дагуу хуульчийн үргэлжилсэн сургалтыг нийслэл болон 21 аймагт зохион байгуулах	Жилдээ	Нийслэлийн болон орон нутгийн хуульчдын сургалт танхимаар зохион байгуулагдсан байна.	2025 онд 33 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2050 хуульч хамрагдснаас 10 сургалтыг танхимаар, 8 сургалтыг цахимаар бусад байгууллагатай хамтарсан 15 сургалт зохион байгуулсан. Хуульчийн үргэлжилсэн сургалтыг Нийслэлд танхимаар дараах байдлаар зохион байгуулсан. - 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Авилгатай тэмцэх газрын хуульчдын сургалт” 2 багц цагийн сургалтад нийт 57 хуульч хамрагдсан. - 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өмчлөх эрхийн хэрэгжилтийг хангаж буй практик, зөрчил” сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 22 хуульч хамрагдсан. Сургагч багшаар Ц.Насанбат; 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд”, “Илт худал мэдээлэл тараах гэмт хэргийн шинж, шалгах ажиллагаа, хууль зүйн дүгнэлт хийх арга зүй” зэрэг сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 78 хуульч

				хамрагдсан. Сургагч багшаар Б.Өнөрмаа, П.Соёл-Эрдэнэ; - 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр “Халдашгүй чөлөөтэй байх эрх”, “Хуульчийн ёс зүй” тус тус сэдвээр 1 багц цагийн сургалтад нийт 68 хуульч хамрагдсан. Сургагч багшаар Б.Энхболд, Я.Мөнхзаяа; - 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр “Барилга уул уурхайн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрүүгийн эрх зүйн хамгаалалт, гадаад орнуудын туршлага” , “ЭХХША-Хөрөнгө буцаах ажиллагаа” сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 24 хуульч хамрагдсан. Сургагч багшаар Г.Оюунбаяр, У.Эрдэнэтуяа нар оролцсон. - 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”, “Эд хөрөнгө хөлсөх ба Түрээсийн гэрээний эрх зүйн зохицуулалт” зэрэг сэдвээр 1 багц цагийн сургалтад нийт 71 хуульч хамрагдсан. - 2025.06.23-ны өдөр “Америкийн нэгдсэн улс дахь баривчлах, цагдан хорих, албадлагын арга хэмжээний онцлог” сэдэвт 0,5 багц цагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 25 хүн хамрагдсанаас 10 хуульчид багц цаг олгосон. - 2025.06.26-ны өдөр "Эрүүгийн хэргийг тохиролцоогоор шийдвэрлэх ажиллагаа" АНУ-ын туршлага судлах 0,5 багц цагийн
--	--	--	--	--

				сургалт зохион байгуулж 53 хуульчид багц цаг олгосон. - 2025.10.16-ны өдөр “Хуульд зааснаар өв залгамжлах, Гэрээслэлээр өв залгамжлах, Өмчлөх эрхийг зөрчих, Өвлөх харилцаа, Өвлөх харилцаа хууль хэрэглээ /процесс ажиллагаа/” сэдэвт 1,5 багц цагийн сургалтыг Орхон аймгийн хуульчдад зохион байгуулж нийт 53 хуульч хамрагдсан. - 2025.10.31-ний өдөр “Технологи үйлдэгдэж ашиглагдаж буй жендерт суурилсан хүчирхийлэл, Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн ойлголт сэдэвт 2024 онд тангараг өргөсөн шинэ хуульчдад зориулсан сургалтыг зохион байгуулж, хуульчдад 1 багц цаг олгосон. - 2025.11.17-ны өдөр "Эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлт", "Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн ялгаатай байдлыг ойлгох нь" зэрэг сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 60 хуульч хамрагдсан. Цахим сургалтын хүрээнд: - 2025.01.30-ны өдөр “Авилгатай тэмцэх газрын хуульчдын сургалт” 2 багц цагийн сургалтад нийт 57 хуульч хамрагдсан. - 2025.03.31-ний өдөр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өмчлөх эрхийн хэрэгжилтийг хангаж буй практик, зөрчил” сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 22 хуульч хамрагдсан. Сургагч багш Ц.Насанбат.
--	--	--	--	--

				- 2025.04.01-ний өдөр “Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд”, “Илт худал мэдээлэл тараах гэмт хэргийн шинж, шалгах ажиллагаа, хууль зүйн дүгнэлт хийх арга зүй” зэрэг сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 78 хуульч хамрагдсан. Сургагч багшаар Б.Өнөрмаа, П.Соёл-Эрдэнэ. - 2025.04.18-ны өдөр “Халдашгүй чөлөөтэй байх эрх”, “Хуульчийн ёс зүй” тус тус сэдвээр 1 багц цагийн сургалтад нийт 68 хуульч хамрагдсан. Сургагч багш Б.Энхболд, Я.Мөнхзаяа. - 2025.06.13-ны өдөр “Барилга уул уурхайн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрүүгийн эрх зүйн хамгаалалт, гадаад орнуудын туршлага”, “ЭХХША-Хөрөнгө буцаах ажиллагаа” сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 24 хуульч хамрагдсан. Сургагч багш Г.Оюунбаяр, У.Эрдэнэтуяа. - 2025.06.20-ны өдөр “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”, “Эд хөрөнгө хөлсөх ба Түрээсийн гэрээний эрх зүйн зохицуулалт” зэрэг сэдвээр 1 багц цагийн сургалтад нийт 71 хуульч хамрагдсан. - 2025.11.10-ны өдөр “Эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлт” сэдэвт 1 багц цагийн сургалт зохион байгуулж нийт 57 хуульч хамрагдсан. - 2025.11.28-ны өдөр “Татварын зөрчил, хариуцлага, Татварын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт 1 багц
--	--	--	--	---

				цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 32 хуульч хамрагдсан. Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт: - 2025.03.31-ний өдөр Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран 68 улсын өмгөөлөгчийг хамруулан, “Улсын өмгөөлөгч, албан хаагчдын чадавхжуулах” 4 багц цагийн сургалтыг зохион байгууллаа. - 2025.04.04-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар, Мөрдөн байцаах албатай хамтран 3,5 багц цагийн сургалтад 68 хуульчийг хамруулан зохион байгуулсан. - 2025 оны 3, 4, 8, 9, 11 дүгээр саруудад Хуульчдын холбооны магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Монголын өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан нийт 381 хуульчдад журмын дагуу 1-4 багц цаг олгосон. - 2025.06.10 Шүүхийн сахилгын хорооны хуульч албан хаагчдад зориулсан, “Эрх зүй ба технологи модуль 1, 2” сэдэвт 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 14 хуульч хамрагдсан. - 2025.09.30 Баянзүрх дүүргийн Прокурорын газартай хамтран 2 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шийдвэрт хууль зүйн дүгнэлт хийх” сэдэвт 2 багц цагийн
--	--	--	--	--

				сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 42 прокурор хамрагдсан. - 2025.09.08-ны өдөр УЕПГ-н Сургалт судалгааны хүрээлэнтэй хамтран “Хүний хөгжлийн мөчлөг, сэтгэл зүйн дархлааг дэмжих тухай ойлголт, Ажлаас халшрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх , Ажлын байран дахь бүтээмж, сэтгэл зүйн дархлаагаа дэмжтх арга зүйн техникүүд” зэрэг сэдэвт 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад нийт 665 прокурор болон хуульч албан хаагчид хамрагдсан. - 2025 оны Улсын дээд шүүхийн хуульч албан хаагчдад зориулсан 4 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 37 хуульчд хамрагдсан. - 2025 оны Хуульчдын холбооны магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Монголын Нотариатчдын танхимаас зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан нийт нотариатчдад журмын дагуу 1-4 багц цаг олгосон. Орон нутгийн сургалтын хүрээнд: - 2025.10.16-ны өдөр “Хуульд зааснаар өв залгамжлах, Гэрээслэлээр өв залгамжлах, Өмчлөх эрхийг зөрчих, Өвлөх харилцаа, Өвлөх харилцаа хууль хэрэглээ /процесс ажиллагаа/” сэдэвт 1,5 багц цагийн сургалтыг Орхон аймгийн хуульчдад сургалт зохион байгуулж нийт 53 хуульч хамрагдсан.
--	--	--	--	--

4.6.	Багц цаг тооцох нөхөн сургалт зохион байгуулах	Жилдээ	Нөхөн сургалт зохион байгуулагдсан байна.	- Танхим болон цахимаар зохион байгуулж буй сургалтын багц цагийг хуульчдын хүсэлтийг харгалзан өмнөх онуудад нөхөн тооцож олгож байна.
4.7.	Албан бус болон мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах	Жилдээ	Санхүүгийн зохицуулах хороо, УЕПГ, МӨХ, ШЕЗ, Нотариатын танхим, АТГ, Хууль зүйн туслалцааны төв, бусад хороод зэрэг байгууллагуудтай хамтран тухайн байгууллагуудын хуульчдын үргэлжилсэн сургалт, мэргэшүүлэх сургалт, захиалгат буюу албан бус сургалтуудыг зохион байгуулсан байна.	Албан бус болон мэргэшүүлэх сургалтыг дараах байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. - 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Авилгатай тэмцэх газартай хамтран “Авилгатай тэмцэх газрын хуульчдын сургалт” 2 багц цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 57 хуульч хамрагдсан. - 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран 68 улсын өмгөөлөгчийг хамруулан, “Улсын өмгөөлөгч, албан хаагчдыг чадавхжуулах” 4 багц цагийн сургалтыг зохион байгуулсан. - 2024 оны 03 болон 04 дүгээр саруудад Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран 142 хуульчийн хамруулан сургалт тус бүр 4 багц цагийн сургалтыг зохион байгуулсан. - 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Шүүхийн сахилгын хороотой хамтран Улсын дээд шүүхийн Тамгын газрын хуульч албан хаагчдад зориулсан, 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба Эрх зүй ба технологи модуль 1, 2 сэдвээр сургалт зохион байгуулж, 14 хуульч хамрагдсан. - Санхүүгийн зохицуулах хороотой хамтран “Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох сургалт”-ыг 05 сарын 13-15 болон 06 сарын 25-27-ны өдрүүдэд 2 удаа зохион

				байгуулсан. Сургалтад нийт 85 хуульч хамрагдсанаас шалгалтад тэнцэж гэрчилгээ авсан 67 хуульч байна. - Боловсролын мэдээллийн технологийн төвийн албан хаагчдад зориулсан албан бус сургалт зохион байгууллаа. Дээрх сургалтыг 2025.05.19-ний өдөр “Цахим гэмт хэрэг” сэдвээр нийт 56 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. 7.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын албан хаагчдад зориулсан албан бус сургалт зохион байгууллаа. - Эдийн засаг хөгжлийн яамны “Хууль зүйн техник: хуулийн төсөл боловсруулах арга зүй” гэрээ сэдэвт Дугаар №ЭЗХЯ/20250203096 тендэрийн дагуу тус яамны албан хаагчдад зориулсан сургалтыг “Хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж, олон нийтээс санал авч боловсронгуй болгох” мэдлэг олгох зорилгын хүрээнд зохион байгууллаа. Сургалтад 33 ажилтан албан хаагч хамрагдсан. Үүнээс 3 хуульч албан хаагч байсан ба хуульчийн үргэлжилсэн сургалтад 2025 оны 2 багц цагийг олгосон.
4.8.	Сургагч багш нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	II улирал	Сургагч багшийн заах арга зүй сайжирсан байна.	- Хэрэгжээгүй
4.9.	Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах багц цаг тооцох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах	I улирал	Сургалтын журмыг боловсронгуй болгох зорилгоор шаардагатай нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.	- Хэрэгжээгүй
Зорилт 5. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийн хүрээнд:				

(ХЭЗБТХ-ийн 45.1.4.) 100%

5.1.	“Хуульчдын эрх, хууль ёсын ашиг сонирхлыг хамгаалах тухай эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	Жилдээ	Оюутнуудыг сэдэлжүүлэх, ёс зүй, хандлага төлөвшүүлэхэд нөлөөлөх эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байна.	- Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хорооноос хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд “Хуульчдын нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцоо” сэдэвт илтгэлийн уралдааныг хоёр үе шаттайгаар зохион байгууллаа. Илтгэлийн уралдааны эхний шатны шалгаруулалтыг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр, эцсийн шатны шалгаруулалтыг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, шилдгүүдийг тодруулсан. Илтгэлийн уралдааны тэргүүн байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Б.Бямбажаргал, дэд байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Б.Оюунтунгалаг, гуравдугаар байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан М.Баяржаргал, Б. Аззаяа, тусгай байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Б.Өсөхбаяр, Б.Мөнхцэцэг нар тус тус шалгарсан. Тус тэмцээний шүүгчээр Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны дарга Ш.Алтангадас, гишүүн Ш.Нарантуяа, Ц.Мөнхбат, Ц.Амарсанаа, П.Эрхэмбаяр нар ажилласан.
5.2.	Хорооны үйл ажиллагааг хуульчдад таниулах, Хуульчдын ажил хэргийн нэр хүндэд халдсан сөрөг ташаа мэдээлэлтэй холбоотой арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	Хуульчдын холбооны зүгээс хүрч чаддаггүй хуульчиддаа хүрч үйлчлэх, тэдний асуудлыг сонсож шийдвэрлэх боломжийг эрэлхийлсэн байна.	- Хуульчдын ажил хэрэг нэр хүндэд халдсан сөрөг ташаа мэдээлэлтэй холбоотой арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд Авилгатай тэмцэх газар болон Шүүхийн ерөнхий зөвлөлд албан бичиг хүргүүлэн ажилласан.
5.3.	“Хуульчдын ажил хэргийн нэр хүндэд халдсан сөрөг ташаа мэдээллийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ,	Жилдээ	Хуульчийн ажил хэргийн нэр хүндийг сэргээх, зөрчигдсөн эрхийг хамгаалах, зохион	- Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хорооноос санаачлан Хуульчдын өдөрт

	хүндрэл бэрхшээл, хууль эрх зүйн зохицуулалт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах		байгуулах ажил арга хэмжээ тодорхой болно.	зориулан “Холбон тоглогч” өглөөний уулзалтыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Илтгэгчээр Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Х.Баасанжаргал, чиглүүлэгчээр Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хорооны дарга Ш.Алтангадас оролцсон.
5.4.	“Залуу хуульчдын группийн уулзалт” – Залуу хуульчдад тулгарч буй асуудал, бэрхшээл шийдвэрлэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах	Жилдээ	Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Үр дүнг МХХ-ны үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээ авсан байна.	- Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн парламентын мэтгэлцээний клубын оюутнуудад 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Үндсэн хуулийг хэн сайн мэдэх вэ? лекцийг хорооны гишүүн Ц.Мөнхбат тавьсан.
Зорилт 6. Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх чиг үүргийн хүрээнд: 25% (ХЭЗБТХ-ийн 45.1.8.)				
6.1.	Хуулийн сургуулийг магадлан итгэмжлэх шинжээчдийг сургалтад хамруулах	Жилдээ	Мэргэжлийн шинжээч бэлтгэгдэнэ	- Хугацаа болоогүй. Боловсролын яамтай хамтарсан Магадлан итгэмжлэх комиссын дүрэм батлагдсаны дараа хийгдэнэ.
6.2.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх асуудлаар санал боловсруулах	Жилдээ	Хуулийн төсөлд санал боловсруулж хүргүүлсэн байна.	- Хугацаа болоогүй. Боловсролын яамтай хамтарсан Магадлан итгэмжлэх комиссын дүрэм батлагдсаны дараа хийгдэнэ.
6.3.	Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 17.14-д заасны дагуу МХХ-ны магадлан итгэмжлэл хийх комиссын магадлан итгэмжлэх эрхийг авах	I-VI сард	Хуульд заасан эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	Уг ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд: - 2025.02.12-ны өдөр Хууль зүй, дотод хэргийн сайдтай уулзаж танилцуулсан. - 2025.02.14-ний өдөр Боловсрол, шинжлэх ухааны сайд Д.Наранбаяртай уулзаж хамтран батлах дүрмийг танилцуулсан. - 2025.03.11-ний өдөр Боловсрол, шинжлэх ухааны яамны Магадлан итгэмжлэлийн үндэсний төвийн захирал болон төлөөллүүдтэй уулзаж дүрмийг боловсруулах, батлуулахад тулгарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцсон.

				- 2025.04.22-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсролын яамны Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн төлөөлөлүүдтэй Хууль зүйн сургуулиудыг магадлан итгэмжлэх асуудал эрхэлсэн хорооны гишүүд "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам", "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага"-ын төсөлд хамтран ажилласан.
6.4.	Хууль зүйн сургуулиудын сургалтын хөтөлбөрийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, хуульч боловсон хүчин бэлтгэх нэгдсэн стандарт боловсруулах	Жилдээ	Хууль зүйн сургуулийн сургалтын нэгдсэн стандартыг боловсруулах	- Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтарсан Магадлан итгэмжлэх комиссын дүрэм батлагдсаны дараа хийгдэнэ.
Зорилт 7. Хууль тогтоох үйл ажиллагаанд мэргэжлийн шинжээчийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөлөл үзүүлэх чиг үүргийн хүрээнд: (ХЭЗБТХ-ийн 45.1.9.)				
7.1.	"Хуульчдын форум-2025" арга хэмжээг талуудтай хамтран зохион байгуулах	Жилдээ	Хуульчдын форум зохион байгуулж, зөвлөмжийг хууль тогтоох болон холбогдох байгууллагуудад хүргэсэн байна.	- Хэрэгжээгүй
7.2.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох санал боловсруулах	I улирал	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна.	- Хэрэгжээгүй
7.3.	Монголын Хуульчдын холбооноос баримтлах стратегийн баримт бичгийг боловсруулах	Жилдээ	Стратегийн баримт бичиг боловсруулсан байна.	- Хэрэгжээгүй
7.4.	Шинээр боловсруулсан болон нэмэлт, өөрчлөлт орж байгаа	Тухай бүр	Хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой	Хуульчдын холбоо 2025 онд дараах 17 хуулийн төсөлд санал хүргүүлсэн. Үүнд:

	хууль тогтоомжоор хэлэлцүүлэг зохион байгуулах, гарсан санал, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх		хуульчдаас гаргасан санал, зөвлөмжийг нэгтгэн тухай бүр холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	- Эрүүгийн хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, - Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, - Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, - Нийтийн өмчийн хуулийн төсөл, - Арилжааны анхдагч хуулийн төсөл, - Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, - Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, - Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, - Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, - Гэр бүлийн тухай хуулийн төсөл - Стандарчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн төсөл - Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (Х.Тэмүүжин) - Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх тухай хуудасны маягт хэрэглэх журам - Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл - Зөвшөөрлийн шинээр бий болгох журмын төсөл - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Захиргааны болон Иргэний хэргийн, Эрүүгийн хэргийн, Зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслүүд.
Зорилт 8.Хууль зүйн шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, шүүхийн практик, хууль зүйн бодлогын чиглэлд судалгаа хийх чиг үүргийн хүрээнд: (ХЭЗБтХ-ийн 45.1.10.)				

8.1.	Эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулиудын дунд Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит “Mock Trial” шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг зохион байгуулах	Жилдээ	Шүүхийн мэтгэлцээн нь хууль зүйн салбарын оюутнуудыг бодит хэрэг, маргаан дээр хэргийн оролцогчдын байр сууринаас оролцох боломжийг олгох, цаашид хууль зүйн сургуулиудын практик судалгааны үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, хууль зүйн боловсролын хөгжлийг дэмжих	- Эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулиудын дунд Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит “Mock Trial” шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг энэ удаад мөн адил шинэ хувилбараар амжилттай зохион байгуулсан билээ. Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хороо, Өмгөөллийн “Легал гайд” ХХК-тай хамтран Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит иргэний хэргийн шүүхийн мэтгэлцээний “Цахим шүүх-Mock trial 2025” тэмцээнийг 2025 оны зургадугаар сарын 7-ны өдөр зохион байгууллаа. - Монголын Хуульчдын холбооноос Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхтэй хамтран Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт шүүх байгуулагдсаны 60 жилийн ойд зориулан Эрүүгийн хэргийн “Мок триал” шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгууллаа.
8.2.	Хуульч, эрдэмтэн, судлаачдын дунд эрдэм шинжилгээний болон онол практикийн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах	Жилдээ	Тухайн цаг үед тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж, зөвлөмж гаргах	- Монголын Хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хороо болон Прокурорын хороо, Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн хамтран 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах нь” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан. - Монголын Хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооноос “Олон улсын

				гэрээний эрх зүйн онол дахь давхар татварын гэрээний байр суурь ба эрх зүйн шинж” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.
8.3.	Хуульчдын оюуны спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын тэмцээнийг зохион байгуулах	Жилдээ	Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын аварга шалгаруулах тэмцээний зорилго нь хуульчдын дунд оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийн ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох	- Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит Шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нийт хуульчдын дунд зохион байгууллаа. Оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох зорилгоор зохион байгуулсан тус тэмцээнд Монголын Хуульчдын холбооны 12 хорооны 36 тамирчин оюун ухаан, ур чадвараа сорин өрсөлдлөө.
8.4.	Хуульч профессор ажиллуулах журмыг боловсруулж, батламж олгох арга хэмжээг зохион байгуулах	Жилдээ	Журмыг баталж, хэрэгжүүлсэн байх	- Хуульч профессор ажиллуулах журмыг Монголын Хуульчдын холбооны Чиг үүргийн болон сайн дурын хороодод руу явуулж, мөн Удирдах зөвлөлийн гишүүд руу явуулж танилцуулж санал авсан болно. Журам эцсийн байдлаар боловсруулах ажил явагдаж дуусаагүй байгаа болно.
Зорилт 9.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулах чиг үүргийн хүрээнд: (ХЭЗБТХ-ийн 45.1.11.) 83%				
9.1.	Алслагдсан сум, дүүрэг, хороодын иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, шаардлагатай гомдол нэхэмжлэлийн эх боловсруулж өгөх үйл ажиллагааг зохион байгуулах	Улирал тутам	Улирал бүр алслагдсан хороодын иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж, тайлан гаргасан байна.	- Нийслэлийн алслагдсан хороод буюу хүн ам ихээр оршин суудаг, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэд төвлөрсөн Сонгинохайрхан дүүргийн 21, 32, 19, 33-р хороо, Баянзүрх дүүргийн 9, 11, 13, 20, 21, 35-р хороо нийт 10 хороонд 11 хуульч, өмгөөлөгчид 10:00 -16:00 цагийн хооронд нийт 81 иргэнд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгсөн.

				- Сонгинохайрхан дүүргийн алслагдсан хороодын иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах чиглэлээр тус дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран ажиллах санамж бичгийг 07 дугаар сарын 07-ны өдөр зурсан. Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж байна.
9.2.	Иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг сар бүрийн 3 дахь 7 хоногийн Лхагва гарагт үргэлжлүүлэн зохион байгуулах	Жилдээ	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд болон тусгай дугаараар сар бүрийн 3 дахь 7 хоногийн Лхагва гарагт Иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан байна.	Нийслэлийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 6 цэг, тусгай дугаарын 4 утсаар дараах өдрүүдэд иргэдэд зөвлөгөө өгөх өдрийг зохион байгуулж нийт 9 удаа 701 иргэнд биечлэн, 130 орчим иргэнд тусгай дугаарын утсаар хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгсөн. - 01 дүгээр сарын 15-ны өдөр нийт 79 иргэнд; - 02 дугаар сарын 19-ний өдөр нийт 69 иргэнд; - 03 дугаар сарын 19-ний өдөр нийт 130 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн ба дээрх үйл ажиллагаанд Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар, Өмгөөллийн Цогц өмгөөлөл, Компас консалтинг, Легас атторнийз хуулийн фирмүүд; - 04 дүгээр сарын 16-ны өдөр 106 иргэнд; - 05 дугаар сарын 01-ний өдөр нийт 69 иргэнд; - 06 дугаар сарын 18-ны өдөр нийт 84 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн ба дээрх үйл ажиллагаанд Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Үйлдвэрчний эвлэлийн холбооны өмгөөлөгчид; - 09 дүгээр сарын 17-ны өдөр 56 иргэнд; - 10 дугаар сарын 15-ны өдөр 62 иргэнд; - 11 дүгээр сарын 19-ний өдөр 46 иргэнд.

9.3.	“Хуульчийн Про Боно өдөр-2025” өдөрлөгийг орон даяар зохион байгуулах	2025.05.01	“Хуульчийн Про Боно өдөр-2025” өдөрлөгийг 5 дугаар сарын 1-ний өдөр орон даяар зохион байгуулж, мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна.	- Жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулдаг Хуульчийн Про боно өдрийг 7 дахь жилдээ Сүхбаатарын талбай болон 21 аймгийн төв талбай, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээ төв, алслагдсан хороод, тойргийн шүүх, хялбар ажиллагааны шүүхийн гадна талбайд зохион байгуулсан. Сүхбаатарын талбайд зохион байгуулсан өдөрлөгт Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчид болон Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэлийн Прокурорын газар, Хан-Уул дүүргийн Прокурорын газар, Чингэлтэй дүүргийн Прокурорын газар, Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар, Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газар, Баянгол дүүргийн Прокурорын газар, Сүхбаатар дүүргийн Прокурорын газар, Тээврийн прокурорын газар, Хүний Эрхийн Үндэсний комисс, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Гадаадын иргэн, харьяатын газар, Архивын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын танхим, Өмгөөллийн
------	---	------------	--	---

				"Легал гайд" ХХН, "Сноухилл консалтанси" ХХН, Өмгөөллийн "Цогц өмгөөлөл" хууль зүйн фирм, Өмгөөллийн Легал полиси ХХН, "Легас атторнийз" хуулийн фирм, "Легал сервис" ХХН, "Эм Жи Эл атторнийз" хуулийн фирм, "Чирха өвгөн" ХХН, "Компасс консалтинг" хууль зүйн фирм, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Клиник сургалтын төв, "Анбаунд Монгол" ТББ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци зэрэг 20 гаруй байгууллага оролцож иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч, төрийн зарим үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн. Хуульчийн Про боно өдрийн хүрээнд Нийслэл болон орон нутгийн хэмжээнд нийт 13,378 иргэнд хууль зүйн, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. - Мөн тус өдрийг угтаж Нийслэл болон 21 аймгийн Ерөнхий боловсролын 8-11 дүгээр ангийн сурагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвээр нийт 72 сургуулийн 7906 сурагчид сургалт зохион байгуулсан. Сургалтаар гэмт хэргийн тухай ойлголт, цахим гэмт хэрэг, түүний хохирогч болохоос урьдчилан сэргийлэх болон цахим донтолтын талаар сурагчдад таниулан, мэдээлэл өгсөн. Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажлын хүрээнд тус сургалтад орон нутгийн шүүхийн шүүгчид, Нийслэл, дүүрэг, орон нутгийн Прокурорын газрын прокурорууд, хуульч, өмгөөлөгч, улсын
--	--	--	--	--

				өмгөөлөгч, 21 аймгийн салбарын зохицуулагчид нийлсэн нийт 76 хүн сургагч багшаар ажилласан.
9.4.	Аж ахуй нэгжийн албан татварын хууль, тогтоомжийг сайжруулахтай холбоотой судалгаа, хэлэлцүүлгийг МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулж тодорхой санал дүгнэлтийг хууль тогтоогчид хүргүүлэх	Жилдээ	Аж ахуй нэгжийн албан татварын хууль, тогтоомжийг сайжруулахтай холбоотой судалгаа, хэлэлцүүлгийг МҮХАҮТ-тай хамтран зохион байгуулж, санал дүгнэлт гарган хууль тогтоогчдод хүргүүлсэн байна.	- Нэгдүгээр сарын 28-ны өдөр “Бизнесийн үйл ажиллагаанд тулгамдаж буй хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын хуулийн зохицуулалтын асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн илтгэгчээр хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Энхчимэг “Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэлийн өнөөгийн нөхцөл байдал (Бизнес эрхлэгчдэд нөлөөлж буй байдал)”, Улаанбаатар хотын худалдааны танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ, хорооны Удирдах зөвлөлийн гишүүн О.Билгүүн нар “Хөдөлмөрийн хуулийн ажил амралтын цаг, цалин хөлсний зохицуулалтын талаарх хэлэлцүүлэг” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлсэн. - Мөн Хуульч, Хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн Б.Солонго “Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн танилцуулгыг хүргэж, “Нийгмийн даатгалын хуулийн үр нөлөө” сэдвээр Улаанбаатар хотын худалдааны танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ, Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН партнер Ө.Эрдэнэ-Очир, ММНБИ-ийн УЗ-ийн гишүүн С.Баярхүү нар хэлэлцүүлэг

				өрнүүлсэн. Тус хэлэлцүүлэгт төрийн болон хувийн байгууллагуудын хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хуульч өмгөөлөгч бүхий 40 гаруй хүн оролцсон. Тус хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Улсын Их хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд хүргүүлсэн.
9.5.	“Монголын Хуульчдын пробоно чуулга уулзалт”-ыг зохион байгуулах	I улирал	Хуульчдын дунд “Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны бодлогын баримт бичиг, цаашдын чиг хандлага” сэдвээр Пробоно чуулга уулзалт зохион байгуулж, санал зөвлөмж гаргасан байна.	- Хэрэгжээгүй.
9.6.	Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны бодлогын баримт бичиг боловсруулж МХХ-ны Зөвлөлөөр батлуулах, дагалдах журмуудыг боловсруулж батлуулах, Захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэх	I-II улирал	Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны бодлогын баримт бичиг боловсруулж МХХ-ны зөвлөлөөр батлуулан, дагалдах журмуудыг захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлсэн байна.	- Хорооны тэргүүн Г.Цагаанбаяр Бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж хорооны хурлаар 2 удаа хэлэлцүүлж, гишүүдээс санал авсан. Баримт бичгийг 09 дүгээр сарын 24-ний өдөр Зөвлөлийн хуралд танилцуулж, Зөвлөлийн хурлаас дахин сайжруулж, нарийвчлах чиглэл өгсөн.
Зорилт 10.Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргийн хүрээнд:				
10.1.	Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээг тогтмол үзүүлэх	Тухай бүр	Зайлшгүй шаардлагатай иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна.	- 2025 оны жилийн эцсийн байдлаар 33 иргэн өмгөөлөгч томилуулах тухай хүсэлт гаргаснаас 23 иргэнд өмгөөлөгч томилсон. Өмгөөлөгч авсан хэргүүдээс 2 хэрэг шүүхийн шатанд шийдвэрлэгдсэн, бусад хэргийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх үйл явц хийгдсээр байна. - 1 иргэний хувьд төлбөрийн чадваргүйг нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн тул татгалзаж шийдвэрлэсэн. 5 иргэнд өмгөөлөгч томилох ажиллагаа хийгдэж

				байна. 4 иргэн өмгөөлөгч томилуулах тухай хүсэлтээсээ татгалзсан.
10.2.	“Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах	Жилдээ	Төлбөргүй чадваргүй иргэдэд туслалцаа үзүүлэхэд өмгөөлөгч нарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэсэн байна.	- Хийгдээгүй.
10.3.	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах.	Жилдээ	Иргэдийн эрх зүйн ухамсар, соёлыг төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилгоор олон нийт болон нийгмийн эмзэг хэсэгт хууль тогтоомжийг бүхий л хэлбэрээр сурталчлан таниулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран /ГХУСЗ, ЗДТГ, ЦЕГ, ГБХЗГ/ зохион байгуулсан байна.	- Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хууль эрх зүй, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх хүрээ, тогтолцоо”, “Хууль зүйн туслалцаа авах эрх”, “Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулийн ялгаа, хууль зүйн ойлголт”, “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвүүдээр эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж, нийт 533 сурагчид хамрагдсан байна.
Зорилт 11.Хуульчдын холбооны гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх				
11.1.	Олон Улсын байгууллагуудын гишүүнчлэлийн хураамж төлөх /IBA, LAWASIA/	I улирал	Гишүүнчлэлээ хадгалах, Гишүүдийг Олон улсын хурал чуулганд оролцох, туршлага судлах боломжоор хангасан байна.	- 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдөр (1,270 Английн фунт) төлсөн. ОУБХ-ноос 03 дугаар сарын 15-ны өдөр 2025 оны гишүүнчлэл баталгаажсан мэйл ирсэн. Ази Номхон далайн Хуульчдын холбоо /LAWASIA/-ны 2025 оны гишүүнчлэлийн хураамж 550 австрали доллар 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр төлсөн
11.2.	13 дахь удаагийн “Азийн Про боно” ээлжит чуулга уулзалтыг Монгол Улсад зохион байгуулах	2025.10.3-5	Про Боно ойлголт, ОУ-ын чиг хандлагыг Монголын хуульчдад таниулан дэлгэрүүлэх, ОУ-ын хуульч өмгөөлөгч, хуулийн фирмийн пробоночидтой хамтран	Азийн 13 дахь удаагийн Про боно чуулга уулзалтыг 2025 оны аравдугаар сарын 01-07-ны өдрүүдэд “Хувьчилсан, төрөлжсөн, байгууллагын тогтсон бүтэц бүхий про боно” сэдвийн дор 30 улсын 310 орчим хуульчид, зохион байгуулагч 50

			ажиллах нөхцөл бололцоог нээх ба тусгай сэдвүүдээр салбар хуралдаанууд зохион байгуулсан байна.	гаруй хүн, нийт 360 оролцогчдыг хамруулан зохион байгуулсан. Тус чуулга уулзалтад Солонгос, Австрали, Америк, Англи, Япон, Малайз, Филиппин, Сингапур, Хонгконг, Пакистан, Орос, Хятад, Тайланд, Швед зэрэг Азийн болон бусад 30 улс орны 140 гаруй хуульч, төлөөлөгч Монгол Улсаас шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульч, Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хуульч, мэргэжилтний төлөөлөл бүхий 160 гаруй хуульч хамрагдсан. Чуулга уулзалтыг угтсан шударга ёсны хүртээмжийн талаарх хэлэлцүүлгийг 10 дугаар сарын 01, 02, 06-ны өдрүүдэд дараах сэдвүүдээр зохион байгуулсан. - 10 дугаар сарын 01-ний өдөр “Хуульчийн ёс зүй ба мэргэжлийн хариуцлага-бизнесийн эрх зүйн практик туршлагауд” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан ба уг хэлэлцүүлэгт Монгол, Тайланд, Австрали, Лаос, Канад, Япон, Сингапур, Англи зэрэг орны 60 гаруй оролцогч оролцож туршлага солилцсон. - 10 дугаар сарын 02-ны өдөр 2 сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан ба “Хууль зүйн клиник боловсролын чиглүүлэг” хэлэлцүүлэгт хуульчид, хууль зүйн мэргэжилтнүүд, хууль зүйн их дээд сургуулийн багш нар оролцож, хууль зүйн клиникийн боловсролын ач холбогдол, чиглүүлэх үйл ажиллагаа, чиглүүлгийн загвар, чиглүүлэгчийн төлөв хандлага, арга техникүүд, тулгардаг бэрхшээл зэрэг
--	--	--	--	--

				өргөн сэдвийн хүрээнд ярилцаж, туршлага солилцсон. Мөн “Про боно долоо хоног” сэдвийн хүрээнд улс орнууд про боно долоо хоногийг хэрхэн хэрэгжүүлдэг, үр дүнд хүрсэн сайн туршлагуудыг хуваалцсан. - 10 дугаар сарын 06-ны өдөр “Про боно үйл ажиллагааг дэмжихэд Хуульчдын холбооны үүрэг” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн илтгэгчээр Bruce Lasky (BABSEACLE байгууллагын үүсгэн байгуулагч, захирал), Mark Woods(Австралийн Хууль зүйн зөвлөлийн Хууль зүйн хүртээмжийн хорооны дарга), Tanguy Lim(“Pro Bono SG”-ийн Гүйцэтгэх захирал), Pram Nath Vijayakumar(“Pro Bono SG”-ийн Олон нийтийн хууль эрх зүйн үйлчилгээний хэлтсийн дэд захирал), Sadhana Rai(“Pro Bono SG”-ийн Төлөөлөгчийн газрын тэргүүн) нар оролцсон. Үндсэн чуулганы өдрүүд буюу 10 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд нийт Нэгдсэн хуралдаан 3, 20 салбар хуралдаан зохион байгуулагдсан.
11.3.	IBA Олон Улсын Барын холбооны 2025 оны чуулга уулзалтад оролцох	2025.11.02-07	Олон улсын Барын холбоотой хамтран ажиллах хамтын ажиллагааг эхлүүлэх, хөгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, туршлага судлах боломжоор хангасан байна /Торонто, Канад/	- Олон Улсын барын холбооны ээлжит чуулга уулзалт 2025 оны 11 дүгээр сарын 02-08-ны өдрүүдэд Канад Улсын Торонто хотод зохион байгуулагдсан бөгөөд Зөвлөлийн гишүүн М.Мөнхбат, Тамгын дарга Ш.Жолбарс нар оролцсон.
11.4.	Ази, Номхон далайн хуульчдын холбооны 5 дахь удаагийн Хүний эрхийн чуулга уулзалтад оролцох	2025.02.15-17	Олон улсын туршлага судлах боломжоор хангасан байна. /Непал, Катманду/	- Оролцоогүй.

11.5.	Ази, номхон далайн бүсийн хуульчдын холбооны 38 дахь удаагийн чуулга уулзалтад оролцох /LAWASIA Annual conference/	2025.10.01-05	Гишүүн хуульчдыг олон улсын хурал, чуулга уулзалтад оролцох боломжийг нэмэгдүүлэх, илтгэл тавих, олон улсын хэлэлцүүлэгч, панелистаар оролцох боломжоор хангасан байна. /Ханой, Вьетнам/	- Хуульчдын холбооны гишүүн хуульч Ж.Хунан 2025 оны 10 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Вьетнам улсын Ханой хотод зохион байгуулагдсан Ази, Номхон далайн 38 дахь удаагийн ээлжит чуулга уулзалтад МХХ-г төлөөлж 2026 онд зохион байгуулагдах Ази, Номхон далайн бүсийн хуульчдын холбооны олон улсын хүний эрхийн 6-р бага хурал болон 2027 онд болох 39 дэх удаагийн ээлжит чуулга уулзалтуудыг тус тус Монгол Улсад зохион байгуулах эрхийг авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцсон.
11.6.	Олон Улсын Барын холбооны тэргүүдийн 18 дахь удаагийн чуулга уулзалтад оролцох	2025.05.21-22	Чуулга уулзалтад оролцож туршлага солилцох боломжоор хангасан байна. /Милан, Итали/	- Оролцоогүй.
11.7.	Монгол Улсын Их Сургууль, Ханнс-Зайделийн сан, Чимид сантай хамтран "Үндсэн хуулийн болон Захиргааны эрх зүйн үндсэн асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах	I-II улирал	"Үндсэн хуулийн болон Захиргааны эрх зүйн үндсэн асуудал" сэдэвт хурлыг зохион байгуулсан байна.	Зохион байгуулагдаагүй.
11.8.	ОУ-ын хуулийн фирм, хамтрагч талуудыг хүлээн авч уулзалт, хэлэлцээр, сургалт, дугуй ширээний ярилцлага зохион байгуулах, хамтарсан хөтөлбөр, сургалт зохион байгуулах цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, гадаад орнуудын туршлага судлах.	Тухай бүр	Гадаадын хуулийн фирмүүд, ТББ, Сангууд, Төрийн байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан сургалт хуульчдын дунд зохион байгуулах, Шаардлагатай хөтөлбөрийг хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх.	- Монголын Хуульчдын холбоо, Герман Европын эрх зүйн төв, УИХ-ын Парламентийн сургалт, судалгаа, хөгжлийн хүрээлэнтэй хамтран "Цахим эрх зүйн олон улсын чиг хандлага" сэдэвт хэлэлцүүлэгийг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулсан. - 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Монголын Хуульчдын холбоо нь АНУ-ын Аризона мужийн Барын холбоотой өдөр цахим уулзалт хийлээ. - "Орчин үеийн хуулийн салбар дахь нарийн төвөгтэй байдлыг даван туулах стратегиуд" сэдэвт хуульчийн карьер,

				хөгжлийн тусгай сургалт, хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан. - Хууль зүй, дотоод хэргийн яам, Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Хууль зүйн сургууль, Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнтэй хамтран “Хиймэл оюун ба эрх зүйн тогтолцоо” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан. - БНСУ-ын Хууль зүйн судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч Хан Ён Сү тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 05 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Монголд зочилсон бөгөөд Төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан. Монголын Хуульчдын холбоо нь БНСУ-ын Хууль зүйн судалгааны хүрээлэнтэй байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд харилцан илтгэл тавих, хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг ажлуудыг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бөгөөд 2025 онд хууль эрх зүйн олон талт судалгааны ажлуудад харилцан дэмжлэг үзүүлэх болон зочин судлаачийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр тохиролсон. - Канадын Холбооны шүүхийн Хэрэг эрхлэх комиссарын газраас “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд (EJAM)” нь төслийг хэрэгжүүлж буйтай холбоотой тус төслийн багийн гишүүн Нью Брансвик мужийн Ерөнхий шүүгч Марк Ричард, Канадын Холбооны шүүхийн Хэрэг эрхлэх комиссарын газрын Олон улсын хөтөлбөрийн хэлтсийн дарга Олег Шахов, хуульч, олон улсын хөгжлийн мэргэжилтэн Ян Моррисон нартай 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр
--	--	--	--	---

				Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс уулзалт хийсэн. - Германы Касселын их сургуулийн Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн эрх зүйн тэнхимийн профессор, Германы холбооны нийгмийн хамгааллын шүүхийн хүндэт шүүгч Феликс Вельти, Касселын их сургуулийн докторант, судлаач С.Амармэнд нарыг 05 дугаар сарын 21-ний өдөр хүлээн авч уулзсан. - Ханнс Зайдел сангийн Мюнхен дэхь төвийн төслийн зохицуулагч Анна Саатбергер болон Монгол дахь суурин төлөөлөгч Феликс Гленк нарыг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авч уулзсан. - ӨМӨЗО-ны Ордос хотын Хуульчдын холбооны төлөөлөгч нарыг 06 дугаар сарын 17-ны өдөр хүлээн авч уулзсан. - АНУ-ын Элчин сайдын яамны Улс төрийн хэлтсийн захирал Эмма Ломаск, АНУ-ын Холбооны Шүүхийн Дипломат албаны Гадаад харилцааны хэлтсийн захирал Мира Гур-Ари, АНУ-ын Холбооны шүүхийн шүүгч Сюзанна Митчелл нарыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч уулзлаа. - АНУ-ын “Зочин илтгэгч” хөтөлбөрийн хүрээнд Монголын Хуульчдын холбооноос АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран “Хуульчдын орчин цагийн сургалтын арга зүй”, “АНУ дахь баривчлах, цагдан хорих албадлагын арга хэмжээний онцлог” сэдэвт сургалт-хэлэлцүүлгүүдийг 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан. - Хууль зүй, дотоод хэргийн яам, Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэн,
--	--	--	--	--

				БНСУ-ын Хувийн эрх зүй судлалын нийгэмлэг, Олон Улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-тай хамтран “Монгол-Солонгосын гэр бүлийн эрх зүй, гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдэвт хамтарсан хэлэлцүүлгийг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. - 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Япон Улсын Айчи мужийн Хуульчдын холбооны төлөөлөгч нарыг хүлээн авч уулзсан.
11.9.	Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөр, донор байгууллагуудтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэх.	Жилдээ	Олон улсын байгууллага, төслүүдтэй хамтран ажиллах хүрээг тэлэх, Хуульчдын холбооны гишүүн хуульчдад хурал, уулзалт, сургалтад оролцох боломжийг нэмэгдүүлнэ.	- Олон Улсын Эрх Зүйн Хөгжлийн Байгууллага нь Канад Улсын Засгийн газрын Санхүүжилтээр “МУ-д жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийг 2019-2023 оны хооронд хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү төслийн хоёрдугаар шатны хэрэгжилт 5 жилийн хугацаатай эхэлж тус төсөлд Монголын Хуульчдын холбоо хамтран ажиллахаар болсон. - АНУ-ын Худалдааны яамны дэргэдэх Арилжааны эрх зүйн хөтөлбөрийн Олон улсын зөвлөх хуульч Гришма Прадханыг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцож, төр хувийн хэвшлийн түншлэл болон хиймэл оюун ухаан, эрчим хүч, дэд бүтцийн чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж хамтран ажиллахаар тохиролцсон.
Зорилт 12. Хууль зүйн судалгааны чиг үүргийн хүрээнд:				
12.1.	Хуульчдыг судалгааны ажилд татан оролцуулах, мэргэшсэн чиглэлээр зөвлөх үйлчилгээнд холбон зуучлах	Жилдээ	Судалгааны төв хуульч судлаачидтай хамтран ажилласан байна.	- Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Прокурорын байгууллагын захиалгаар тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн судалгааг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

				- УИХТГ-ын Парламентийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захилгаар дараах хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийт 16 судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр судлав. 1.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль; 2.Бүх нийтийн үүргийн үүргийн санд холбогдох хууль тогтоомж; 3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлэг; 4.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн төлөв байдлыг судлав. - УИХ-ын гишүүн Д.Бум-очирын захилгаар Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тан судлав.
12.2.	Хууль зүйн чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээ хийх	Улирал тутам	Дангаар болон бусад байгууллагатай хамтран судалгаа, дүн шинжилгээний ажлыг хийсэн байна.	- Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг тандан судлах Стандартын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Нийгмийн ажлын тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, Жижиг дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах зэрэг нийт 5 үнэлгээ, тандан судалгааны ажлыг захиалгаар болон бусадтай хамтран хийж гүйцэтгэсэн.
12.3.	Судлаачдын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, залуу судлаачдыг чадавхжуулах	Улирал тутам	Судлаачдыг дэмжих, хамтран ажиллах тогтолцоо бий болсон байна.	- Судлаачдын уулзалтыг 2 удаа зохион байгуулж, судалгааны арга зүйн чиглэлээр чадавхижуулах сургалтад нийт 8 хуульчийг хамруулсан. .
Зорилт 13. Хуульчдад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах				

13.1.	Хуульчдад зориулсан эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулах	Жилдээ	Гишүүн хуульчдад зориулж үйлчилгээ үзүүлсэн байна.	- Холбооны орон нутгийн салбарын 10 зохицуулагчийг ӨМӨЗО-ны нийслэл Хөх хотын Хуульчдын холбоо, хуулийн фирмийн үйл ажиллагаатай танилцуулах, туршлага судлах, мөн эрүүл мэндийн шинжилгээ өгөх аялалыг 2025 оны 05 дугаард сард Тамгын газраас зохион байгуулсан. - Хуульчдын өдрийг тохиолдуулан 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Хуульчдын эрүүл мэндийн өдөрлөгийг Монгос групптэй хамтран зохион байгуулав. Өдөрлөгт Хуульчдын холбооны 87 гишүүн хуульч, Тамгын газрын ажилтнууд, УИХТГ-ын парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн ажилтнууд оролцож эрдсийн шинжилгээ, ясны сийрэгжилт, хэвлийн эхо, сахар, даралт, хелико бактерийн шинжилгээг өгч эрүүл мэндийн анхан шатны зөвлөгөө мэдээлэл авлаа.
13.2.	Хуульчдын төгөлд мод тарих	V, X сард	Нийгэмд тустай ажил хийсэн байх	- Хэрэгжээгүй.
13.3.	Хуульчдын спорт тэмцээн, явган аяллын тэмцээнийг зохион байгуулах	Жилдээ	Хуульчдын эрүүл мэнд, чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх	- Монголын Хуульчдын холбооны Булган аймаг дахь салбар нь Булган аймгийн Нотариатын салбартай хамтран "Нотариатын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой"-г тохиолдуулан Хууль, хүчний байгууллагын албан хаагчдын дунд спортын   3 төрөлт тэмцээнийг зохион байгуулсан. - Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооноос санаачлан Тамгын газартай хамтран "Цэвэр агаар-Эрүүл хуульч" өдөрлөгийг 2025 оны хоёрдугаар сарын 01-ний өдөр Манзуширын аманд байрлах "Овооны энгэр" жуулчны баазад зохион байгуулсан.

				- 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан Чимид багшийн нэрэмжит шатрын тэмцээнд хуульч Ц.Мөнхбат оролцсон. - Тагнуулын ерөнхий газрын нэрэмжит Хуулийн байгууллагуудын аварга шалгаруулах “Шатар”-ын тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдсан тэмцээнд холбооноос баг бүрдүүлж оролцсон. - 2025 оны хуулийн төв байгууллагын 6 төрөлт спорт тэмцээнд Монголын Хуульчдын холбооны баг тамирчид амжилттай оролцож шатрын төрөлд Ц.Мөнхбат ахлагчтай баг мөнгөн медаль, ширээний теннис дээр Т.Жавхлантөгс шүүгч эрэгтэй төрөлд мөнгөн медаль, хосын төрөлд Т.Жавхлантөгс, Д.Одонтунгалаг нар мөнгөн медаль тус тус хүртсэн. - Монголын Өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан 2025 оны хөлбөмбөгийн тэмцээнд мөн оролцсон. - Шихихутуг Их сургуулийн 2025 оны хуулийн төв байгууллагуудын дунд зохион байгуулдаг шатрын тэмцээнд оролцсон. - Монголын Нотариатчдын танхимаас зохион байгуулсан шатрын 2025 тэмцээнд оролцсон.
14.Бусад. Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хүрээнд:				
14.1.АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУСГАСАН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ХҮРЭЭНД:				
14.1.1	5.4.2.1. Авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр прокурорыг мэргэшүүлэх	Жилдээ	Сургалт зохион байгуулсан байх	- Хэрэгжээгүй
14.1.2	6.1.1.1. Хөрөнгө буцаасан, мэдээлэл солилцсон,	Жилдээ	Сургалт зохион байгуулсан байх	- Хэрэгжээгүй

	хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулсан олон улсын туршлагад тулгуурлан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах			
14.1.3	Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан сонгуулийн үеэр санал худалдан авахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгож, гэмт хэрэг, зөрчилд оногдуулах хариуцлагыг тодорхой болгох	Жилдээ	Хуулийн зохицуулалт боловсронгуй болгох чиглэлээр санал өгсөн байна	- Эрүүгийн эрх зүйн хороо, Судалгааны төв хамтран сонгуулийн гэмт хэргийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.
14.1.4	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд санал худалдан авахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох	Жилдээ	Хуулийн зохицуулалт боловсронгуй болгох чиглэлээр санал өгсөн байна	- Эрүүгийн эрх зүйн хороо, Судалгааны төв хамтран Хууль зүй, дотоод хэргийн яам, УИХ-ын зарим гишүүний санаачилсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд санал худалдан авахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал хүргүүлж 2025 оны 6 дугаар сард тус нэмэлт, өөрчлөлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан.
14.1.5	Улсын Их Хурлын гишүүн өөрөө эцсийн өмчлөгч, эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшдэг хуулийн этгээдийн явуулж байгаа аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн төсөл санаачлах, санал гаргахыг хязгаарласан эрх зүйн орчныг бүрдүүлэх	Жилдээ	Хуулийн зохицуулалт боловсронгуй болгох чиглэлээр санал өгсөн байна	- Судалгааны төвөөс Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг 2024 онд тандан судалсан бөгөөд энэ хүрээнд УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар нарын санаачилсан Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал хүргүүлж 2025 оны 6 дугаар сард тус нэмэлт, өөрчлөлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар баталсан байна.
14.2.БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЗӨРЧИГДСӨН ЭРХИЙГ СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023-2027)				
Хүний эрхийг хангах, хамгаалах талаарх төрийн үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ				

14.2.1	Хөдөлмөр эрхлэлтийн талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх зорилгоор хууль зүйн мэргэшсэн туслалцаа үзүүлэх хуульчдыг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх	Жилдээ	Хууль зүйн мэргэшсэн туслалцаа үзүүлэх хуульч, өмгөөлөгчдийг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх сургалт, үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулсан байна.	- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас аж ахуйн нэгж, байгууллагуудад Хөдөлмөрийн харилцааны зөв соёлыг төлөвшүүлэх зорилгоор мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтыг 2025 оны зургадугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтад Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн В.Болормаа, Г.Халиун, Ч.Өнөржаргал, Э.Золжаргал, Тамгын газрын ахлах мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн нар хамрагдаж, “Мэргэшсэн зөвлөх”-ийн гэрчилгээ авсан.
Хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах талаар аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ				
14.2.2	Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх	Жилдээ	Хууль, эрх зүйн туслалцаа, зөвлөх үйлчилгээний компани, иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах, оролцоог хангах арга хэмжээг үе шаттай төлөвлөж хэрэгжүүлсэн байна.	- Хүний эрхийн Үндэсний Комисс, Эмнэсти Интернэшнл байгууллагатай хамтран “Хүний эрхийн боловсрол” олон улсын симпозиумыг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав.
Зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах хууль, эрх зүйн орчныг бэхжүүлэх, үр нөлөөг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлэх:				
14.2.3	Уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлийн талаарх хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг боловсронгуй болгох	Жилдээ	Судалгаа хийж, хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой журмын төсөлд санал өгсөн байна.	- Захиргааны эрх зүйн хорооноос Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтран “Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн хүрээнд ХББОСЯ-ны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат “Хот байгуулалтын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага” сэдвээр, Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч Ж.Сайнхишиг “Хот байгуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт

				хийсэн үнэлгээ, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэл” сэдвээр, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын Хуулийн хэлтсийн дарга Я.Болор “Хот төлөвлөлтийн шийдвэр гаргах процесс: Эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал” сэдвээр, Хот байгуулалт, хотын стандартын газрын Дэд төв дагуул хотын хөгжлийн хэлтсийн хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөнд хийсэн үнэлгээний тайлан” сэдвээр, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ганзориг Хот байгуулалт, дахин төлөвлөлттэй холбоотой захиргааны актад хамаарах маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” сэдвүүдээр тус тус илтгэл хэлэлцүүлсэн.
14.2.4	Бизнес ба хүний эрхийн асуудлаар прокурор, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын мэдлэг, ойлголтыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	Хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, чадавх бэхжүүлэх сургалт, арга хэмжээг үе шаттай зохион байгуулсан байна. Сургалтын агуулгад жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалт, жендэрийн мэдрэмжтэй хандах агуулгыг тусгасан байна.	- 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар Жендэрийн үндэсний хорооны дарга Т.Энхбаяр болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)-нд тусгагдсан хуульчийн үйл ажиллагаа болон хуульчдыг сонгон шалгаруулах тогтолцоонд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар нийтийн эрх ашгийн өмгөөлөл явуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх санал, санаачилгын талаар санал солилцов. Монгол Улсад бүртгэлтэй 6853 хуульч, үүнээс 41,8 % нь эрэгтэй, 58,2% нь эмэгтэй байгаа бөгөөд хуульчдыг

				сургалтын тогтолцоогоор дамжуулан жендэрийн ойлголт мэдлэгтэй, жендэрийн мэдрэмжтэй болгох асуудал чухал байгааг онцлоод цаашид эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулиудын хичээлийн агуулгад жендэрийн үзэл баримтлалыг тусгах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг ойлгож хэрэглэх зөвлөмж, гарын авлага гаргах, жендэрийн сургагч багш бэлтгэх болон холбогдох бусад асуудлаар нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан хамтарч ажиллахаар харилцан тохиролцлоо. - 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ) нь Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” (2025–2030) төслийн хоёрдугаар шатыг нээлээ. 5 жилийн хугацаатай хэрэгжих уг төсөл гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд Засгийн газар, хууль сахиулах, шүүх эрх мэдэл, болон иргэний нийгмийн байгууллагын тусламж үйлчилгээнд хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэн, салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах зорилготой ба хамтран хэрэгжүүлэгч байгууллагаар Хуульчын холбоо ажиллаж байна.
14.2.5	Шүүхийн мэргэжлийн шинжээчдийг бэлтгэх, чадавхыг сайжруулах арга хэмжээ авах	Жилдээ	Хүний нөөцийг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажилласан байна.	- Хэрэгжээгүй
14.2.6	Шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг төрөлжүүлэн хөгжүүлэх,	Жилдээ	Хэлэлцүүлэг, судалгаа зохион байгуулж, дүгнэлт, санал боловсруулсан байна.	- Хөдөлмөрийн харилцаан дахь Эвлэрүүлэн зуучлал” сэдэвт өглөөний

	шийдвэрийг баталгаажуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх асуудлаар судалгаа, дүгнэлт гаргах, эвлэрүүлэн зуучлагчдыг чадавхжуулах, урамшуулах тогтолцоог бий болгох		Дүгнэлт, саналын мөрөөр хууль тогтоомжийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн байна.	уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны хоёрдугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, нийт 30 гаруй хуульч хамрагдав. - “Эвлэрүүлэн зуучлалын Олон Улсын туршлага” сэдэвт өглөөний уулзалтыг 2025 оны есдүгээр сарын 26-ны өдөр Хуульчдын ордонд зохион байгуулж, илтгэгчээр Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, Лондон дахь Маргааныг үр дүнтэй шийдвэрлэх төвийн мэргэшсэн эвлэрүүлэгч, Лондон дахь Итгэмжлэгдсэн арбитрчдын институтийн эрдэмтэн гишүүн, өмгөөлөгч Ц.Санжаалхам, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, Олон Улсын Хуульчдын холбооны гишүүн, Гадаад худалдааны маргаанаас урьдчилан сэргийлэх ба шийдвэрлэх Олон улсын байгууллагын хяналтын зөвлөлийн гишүүн, Олон Улсын арбитрч, өмгөөлөгч С.Уянгаа, Монголын Хуульчдын холбооны ахлах мэргэжилтэн, хуульч, судлаач Ж.Бариаширсүрэн нар оролцов. - Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт хорооны тэргүүн Д.Түмэнжаргал, Удирдах зөвлөлийн гишүүн Э.Цолмон, Э.Одонтуяа нар ажиллаж байна. Энэ хүрээнд тус гишүүдийн зүгээс холбооны дэргэд Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулах санал гаргаж, тус ажлын хэсэг нь нийт 4 удаагийн уулзалтыг
--	---	--	--	---

				зохион байгуулж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Монголын Хуульчдын холбооноос өгөх саналыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлээд байна. - “Монгол Улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” (2023-2025) төслийн хүрээнд “Арилжааны эвлэрүүлэн зуучлалын чиглэлд эвлэрүүлэн зуучлагчдын чадавхыг бэхжүүлэх” сургалтыг IDLO-той хамтран 2025 оны тавдугаар сарын 12-13-ны хооронд зохион байгуулав. Тус сургалтад Хорооны тэргүүн Д.Түмэнжаргал, Удирдах зөвлөлийн гишүүн З.Тунгалагмаа сургагч багшаар, УЗ-ийн гишүүн Ц.Амарсанаа илтгэгчээр оролцсон бол УЗ-ийн гишүүн Э.Цолмон, Г.Энхтуяа, хорооны гишүүн Э.Одончимэг, Г.Ган-Эрдэнэ, Д.Наранцэцэг, Б.Тогоодулам, С.Бүжинлхам нар оролцлоо. - 'Why mediation?, Why for businesses?' сэдэвт мэдээлэл хүргэх арга хэмжээг Дархан-Уул аймагт зохион байгуулсан бөгөөд Дархан-Уул аймагт хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга, уул уурхай, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид, эрдэмтэн судлаач, нотариатч, хуульч, өмгөөлөгч, шүүхийн байгууллагын нийт 50 гаруй төлөөлөл оролцов. - Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хорооноос санаачлан 'Why
--	--	--	--	---

				mediation? Why for Lawyers?’ сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулав. Монголын Хуульчдын холбоо болон Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч, шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, нотариатч зэрэг 60 гаруй төлөөлөл оролцож, эвлэрүүлэн зуучлал нь шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх үр дүнтэй ажиллагаа болох талаар сургалтад хамрагдаж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан арилжааны эвлэрүүлэн зуучлалын шинэчлэлийн талаар хэлэлцүүлэг өрнүүлж, эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үүний үр дүнд арилжааны болон бизнесийн шинжтэй маргааныг илүү үр дүнтэй шийдвэрлэх, шүүхийн ачааллыг бууруулах болон олон нийтийн эвлэрүүлэн зуучлалд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэлээр санал солилцсон. - Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хороо, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн төлөөлөл уулзаж, хуульчдад зориулсан эвлэрүүлэн зуучлалын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах асуудлаар ярилцсан. Энэхүү уулзалтаар хуульчдад зориулсан эвлэрүүлэн зуучлалын сургалтын хөтөлбөрийг орчин үеийн сургалтын арга зүй, хэлбэр,
--	--	--	--	--

				шаардлагад тулгуурлан видео болон танхимын хэлбэрээр боловсруулж, магадлан итгэмжлүүлэхээр Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороонд хүргүүлсэн бөгөөд Сургалтын хорооноос тус хөтөлбөрийг магадлан итгэмжилж шийдвэрлэлээ.
14.3. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ /2022-2031/				
14.3.1	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан МХХ-ны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, тайлагнах	Хагас жилд	МХХ-ноос 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан байна.	- Хуульчдын холбоо Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай тухайлсан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулаагүй.Үндэсний хөтөлбөрийн дагуу тайланг тогмол хүргүүлж ажилласан. - 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар Жендэрийн үндэсний хорооны дарга Т.Энхбаяр болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031 он) тусгагдсан хуульчийн үйл ажиллагаа болон хуульчдыг сонгон шалгаруулах тогтолцоонд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар нийтийн эрх ашгийн өмгөөлөл явуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллахаар төлөвлөж байна. - Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн хоёр дахь шатыг Канад Улсын Засгийн газрын

				санхүүжилтээр 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд Монголын Хуульчдын холбоо нь тус төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх, жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд хуульчдын ур чадвар, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллахаар болсон. Төслийн талаар санал солилцох Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын суурин төлөөлөгч Чарльз Болландтэй уулзах уулзалтад Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хорооны тэргүүн Д.Түмэнжаргал оролцов.
14.4. ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН 2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 09-НИЙ ӨДРИЙН А/04 ДҮГЭЭР ТУШААЛААР БАТЛАГДСАН “МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ				
14.4.1.	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан МХХ-ны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, тайлагнах	Улирал тутамд	МХХ-ноос 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан байна	- Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/2 тушаалаар "Монголын Хуульчдын холбооны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"- г баталж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажилласан. - Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улс дахь траст болон компани, түүнтэй төстэй төрлийн үйлчилгээний практик нөхцөл байдлын судалгааг хийх, холбогдох дата мэдээллийг цуглуулах асуулгад 100 гаруй хуульч, 53 өмгөөллийн нөхөрлөлийн хүрээнд судалгаанд хамруулж 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн Санхүүгийн зохицуулах хороо болон

				Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан Комплаенсын ажилтныг мэргэшүүлэх ахисан шатны сертификаттай сургалт, хуульчдад мэдлэг олгох сургалтын зарыг түгээж хуульчдыг хамруулсан. - Санхүүгийн мэдээллийн албанд улирал тутам үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан болон холбогдох статистик мэдээг маягтын дагуу хүргүүлсэн. - ФАТФ-ын хориг арга хэмжээний жагсаалтад орсон улс орнуудын мэдээллийг тухай бүр шинэчдэн байршуулсан. - ХЗДХ-ийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/171 дүгээр "Дэд ажлын хэсэг байгуулах тухай" тушаалаар байгуулагдсан "Санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчийн эмзэг байдлын үнэлгээ хийх дэд ажлын хэсэг (Модуль7)-гийн Дэд ахлагчаар ажиллаж салбарын эрсдэлийн үнэлгээний ажлын хуудас боловсруулсан ба тайлан гаргасан. Нэгдсэн дүгнэлт боловсруулах ажил үргэлжилж байна. 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан Үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх шинжээчдийн сургалтад ахлах мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн хамрагдсан. - Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанаас холбооны Зөвлөлийн гишүүдэд МУТСТ арга хэмжээний талаар сургалт орсон. - ХАЗ-ын дэргэдэх Судалгаа, дүн шинжилгээний ажлын хэсгийн хуралд 2 удаа оролцсон.
--	--	--	--	---

				- ХАЗ-ын дэргэдэх Хяналт шалгалтын ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж Үндэсний эрсдэлийн үнэлгээний багт комплаенс хариуцсан мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн ажиллаж байна. - Хуульчдын холбооны цахим хуудаст "Комплаенс" цэс шинээр бий болгож, шаардлагатай мэдээллийг оруулж байна. - МХХ-ны МУТСТ хөтөлбөрийн төсөл, Монголын хуульчдын холбооны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт шалгалт хийх журам-ын төсөл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны эрсдэлийг үнэлэх зайны хяналт хяналт шалгалтын асуулга-ын төсөл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны эрсдэлийг үнэлэх газар дээрх хяналт шалгалт хийх зөвлөмж-ийн төслийг тус тус боловсруулан эрх бүхий байгууллага, хуульчдаас санал авах ажлыг зохион байгуулж сайжруулан холбооны Зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэн батлаагүй байна. - Хуульчдын зургадугаар Их хурлаас холбооны дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд хуульчийн нийтлэг үүрэгт "МУТСтХ-д заасан үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд мэдүүлэх үүргийг тухайлан тусгуулсан.
--	--	--	--	--

ТАМГЫН ГАЗАР